

Төлөөлөн удирдах зөвлөлийн
2024 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн
47 дугаар тогтоолын хавсралт



**“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК-ИЙН
ҮНЭТ ЦААС ГАРГАГЧААС ОЛОН НИЙТЭД ХҮРГЭХ МЭДЭЭЛЛИЙН ЖУРАМ**
/Шинэчилсэн найруулга/

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧААС ОЛОН НИЙТЭД ХҮРГЭХ МЭДЭЭЛЛИЙН ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл	2
Хоёр.Нийтэд мэдээлэх үйл ажиллагаа	2
Бирж ба үнэт цаас гаргагчийн харилцаа	2
Мэдээллийг нийтэд хүргэх	3
Үнэт цаас гаргагчийн цахим хуудас	4
Гурав.Мэдээллийн ил тод байдал.....	4
Үнэт цаас гаргагчийн нийтэд мэдээлэх хугацаат мэдээлэл.....	4
Үнэт цаас гаргагчийн тухай бүр нийтэд мэдээлэх мэдээлэл	6
Дөрөв.Хяналт, хариуцлага.....	8
Тав.Маргаан шийдвэрлэх	8

“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК-ИЙН ҮНЭТ ЦААС ГАРГАГЧААС ОЛОН НИЙТЭД ХҮРГЭХ МЭДЭЭЛЛИЙН ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

- 1.1. Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журмаар үнэт цаас гаргагчаас хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдэд хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээлэл болон үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөх бусад мэдээллийг тогтоосон хугацаанд олон нийтэд ил тод нээлттэй хүргэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Энэхүү журмыг "Монголын хөрөнгийн бирж" ХК (цаашид "Бирж" гэх)-д үнэт цаасаа бүртгүүлсэн үнэт цаас гаргагч, түүний Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ" гэх)-ийн дарга, гишүүн, компанийн эрх бүхий албан тушаалтан, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нар дагаж мөрдөнө.
- 1.3. Журмыг хэрэгжүүлэхдээ хууль дээдлэх, ил тод, бодитой, үнэн зөв, шуурхай байх зарчмуудыг баримтална.
- 1.4. Биржид давхар болон хоёрдогч бүртгэл хийлгэсэн гадаад улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй этгээд энэхүү журмыг дагаж мөрдөх хэдий ч Биржийн "Үнэт цаасны бүртгэлийн журам"-д заасан хөнгөлөлт, чөлөөлөлтийг эдэлж болно.
- 1.5. Энэхүү журамд тусгагдсан нэр томъёог дараах утгаар ойлгоно. Үүнд:
 - 1.5.1. "бүртгэлтэй үнэт цаас гаргагч" гэж биржид үнэт цаасаа бүртгүүлсэн аливаа хуулийн этгээдийг;
 - 1.5.2. "тогтвортой хөгжлийн менежмент" гэж компанийн бизнесийн болон дотоод үйл ажиллагааг тогтвортой хөгжил, үйлдвэрлэл, үйлчилгээний зарчмуудтай нийцүүлэхэд шаардлагатай удирдлагын систем (засаглал, бодлого, журам, хариуцсан ажилтан, сургалт, хяналт)-ийг цогцоор нь бүрдүүлэхийг.

Хоёр.Нийтэд мэдээлэх үйл ажиллагаа

Бирж ба үнэт цаас гаргагчийн харилцаа

- 2.1. Үнэт цаас гаргагчаас ирүүлж буй мэдээлэл нь Монгол хэл дээр үйлдэгдсэн байх ба энэхүү журамд заасан болон бусад шаардлагатай тохиолдолд нэмэлт мэдээллийг гадаад хэл дээр үйлдэж болно.
- 2.2. Үнэт цаас гаргагч нь баримт, мэдээллээ цаасан эсхүл цахим хэлбэрээр ажлын өдрийн 15 цагаас өмнө Биржид ирүүлэх бөгөөд 15 цагаас хойш ирүүлсэн баримт, мэдээллийг дараагийн ажлын өдөрт олон нийтэд хүргэнэ.
- 2.3. Утсаар болон цахим шуудангаар харилцах тохиолдолд Биржээс шаардлагатай гэж үзвэл үнэт цаас гаргагчийг төлөөлж харилцах эрхтэй этгээдийг нотлох буюу батлах баримт бичгийг шаардаж болно.
- 2.4. Үнэт цаас гаргагч нь энэхүү журмын 2.3-т заасан баримт материалыг цаасан эсхүл цахим хэлбэрээр хууль тогтоомж, журам, зааварт тогтоосон хугацаанд Биржид хүргүүлнэ.

- 2.5. Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн хүсэлтийн шинж чанар, ач холбогдол, цар хүрээ зэргээс хамаарч Бирж нь хариуг утсаар эсхүл биечлэн уулзаж өгч болно.
- 2.6. Бирж нь өөрийн цахим хуудас болон цахим шуудангаар дамжуулан холбогдох этгээдэд аливаа мэдээлэл, мэдэгдэл, шаардлага, анхааруулга зэргийг хүргүүлж болно.
- 2.7. Компаниас цаасан эсхүл цахим хэлбэрээр ирүүлсэн мэдээллийг хянах, хавтаст материалд хадгалах, бүртгэл хөтлөх, боловсруулах, түүнийг нийтийн хүртээл болгох ажлыг Биржийн Бүртгэл хариуцсан нэгж хариуцна.
- 2.8. Мэдээллийн сан бүрдүүлэх, түүнийг хадгалах ба мэдээллийн сангийн болон мэдээлэл хүлээн авах, түгээх үйл ажиллагааны аюулгүй, найдвартай байдлыг Биржийн Мэдээлэл технологи хариуцсан нэгж хариуцна.

Мэдээллийг нийтэд хүргэх

- 2.9. Үнэт цаас гаргагчийн мэдээллийг өөрийн болон биржийн цахим хуудсанд байршуулах үүргийг үнэт цаас гаргагч компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга эсхүл Гүйцэтгэх удирдлагаас томилсон үнэт цаас хариуцсан ажилтан гүйцэтгэх бөгөөд мэдээллийн үнэн зөвийг үнэт цаас гаргагч компани өөрөө бүрэн хариуцна.
- 2.10. Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга болон үнэт цаас хариуцсан ажилтныг томилсон тухай шийдвэр, түүний анкетыг Биржид ажлын 3 өдрийн дотор ирүүлнэ. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга эсхүл үнэт цаас хариуцсан ажилтан нь үнэт цаас гаргагчийн тогтмол биелүүлэх үүргийн хэрэгжилтийг хангах үндсэн чиг үүрэгтэй этгээд байна.
- 2.11. Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга болон үнэт цаас хариуцсан ажилтан нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна.
- 2.12. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга эсхүл үнэт цаас хариуцсан ажилтныг томилсон шийдвэрийг хүлээн авч, шаардлага хангасан гэж үзвэл Биржийн цахим хуудаст хандаж мэдээ байршуулахад ашиглах нэвтрэх нэр, нууц үг бүхий эрхийг Биржээс олгоно.
- 2.13. Биржийн цахим хуудаст нэвтрэх эрхийг зориулалтын бусаар ашиглах, бусдад дамжуулах, санаатай болон санамсаргүй байдлаар бусдад олгохыг хориглох бөгөөд үүнээс үүдэх хариуцлагыг компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга эсхүл үнэт цаас хариуцсан ажилтан хүлээнэ.
- 2.14. Компани энэ журамд заасан мэдээллийг нийтэд хүргэх харилцааг зохицуулсан дотоод журам баталж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж болно.
- 2.15. Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга эсхүл үнэт цаас хариуцсан ажилтан нь мэдээллийг холбогдох хууль тогтоомж болон энэ журамд заасан хугацаанд үнэн зөв, бүрэн гүйцэд мэдээлж байгаа эсэхэд үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнууд тогтмол хяналт тавина.
- 2.16. Бирж нь үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигч, оролцогч бусад этгээдээс ирүүлсэн үндэслэл бүхий гомдол, хүсэлт болон олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаар тархсан цуурхалтай холбоотойгоор үнэт цаас

гаргагчаас нэмэлт мэдээлэл, тайлбар гаргуулан авч, шаардлагатай тохиолдолд олон нийтэд хүргэж болно.

- 2.17. Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн аливаа мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд өөрчлөлт оруулах болсон шалтгаан, тайлбарыг тодорхой бичиж, өөрчлөлт орсон хугацаанаас хойш ажлын 2 өдрийн дотор албан байдлаар ирүүлнэ.

Үнэт цаас гаргагчийн цахим хуудас

- 2.18. Үнэт цаас гаргагч нь албан ёсны цахим хуудастай байх бөгөөд цахим хуудаст хувьцаа эзэмшигчдэд зориулсан цэстэй байна.
- 2.19. Үнэт цаас гаргагчийн цахим хуудас нь байнгын, идэвхтэй үйл ажиллагаатай байна.
- 2.20. Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй холбогдох хууль, журамд заасан мэдээ мэдээллийг өөрийн болон Биржийн цахим хуудаст нэгэн зэрэг мэдээлнэ.
- 2.21. Энэ журмын 2.17-д заасан мэдээллийг Бирж тухай бүр Хороонд мэдээлнэ.

Гурав.Мэдээллийн ил тод байдал

Үнэт цаас гаргагчийн нийтэд мэдээлэх хугацаат мэдээлэл

- 3.1. Үнэт цаас гаргагчийн хугацаат тайлагнал нь жил, хагас жилийн үйл ажиллагааны тайлан хэлбэртэй байна. Үнэт цаас гаргагч жилийн үйл ажиллагааны тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг дараа сарын 20-ны өдрийн дотор Биржид ирүүлнэ.
- 3.2. Үнэт цаас гаргагч нь санхүүгийн тайлангаа Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (IFRS)-д нийцүүлэн үнэн зөв гаргаж жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 02 дугаар сарын 10-ны дотор, хагас жилийн санхүүгийн тайланг дараа сарын 20-ны дотор, улирлын санхүүгийн тайланг дараа сарын 20-ны дотор Биржид ирүүлнэ.
- 3.3. Хорооноос зөвшөөрөгдсөн аудитын байгууллагаар баталгаажуулсан аудитлагдсан тайланг үнэт цаас гаргагч нь тайлант жил дууссанаас хойш 04 дүгээр сарын 10-ны дотор Биржийн цахим хуудаст байршуулж олон нийтэд мэдээлнэ.
- 3.4. Энэхүү журмын 3.1-д заасан үйл ажиллагааны тайлан, 3.2-д заасан санхүүгийн тайлан, 3.3-д заасан аудитлагдсан санхүүгийн тайланг Биржийн үнэт цаасны бүртгэлийн I ангилалд бүртгэлтэй үнэт цаас гаргагч нь Монгол болон Англи хэл дээр гаргаж ирүүлнэ.
- 3.5. Үнэт цаас гаргагч нь санхүү, үйл ажиллагааны тайлангийн мэдээллийг Хорооноос баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын дөрөвдүгээр хавсралтын маягт 1, маягт 2-ын дагуу ирүүлнэ. Түүнчлэн доорх мэдээллийг жил, хагас жилийн үйл ажиллагааны тайланд тусгаж ирүүлнэ. Үүнд:
- 3.5.1. үнэт цаас гаргагчийн бүтэц (толгой, охин, хараат, зэргэлдээ компаниуд, тэдгээрийн хувь эзэмшлийн талаар), холбоотой талуудын санхүүгийн гүйлгээний талаарх мэдээлэл;
- 3.5.2. үнэт цаас гаргагч нь (Банк, Даатгал, Банк бус санхүүгийн байгууллага, болон Үнэт цаасны компани) төлбөрийн чадвар, зохистой харьцааны шалгуур үзүүлэлт;

- 3.5.3. үнэт цаас гаргагч нь өөрийн гаргасан хувьцааг эргүүлэн худалдан авч, хүчингүй болгох замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг бууруулах, компанийн алдагдал тухайн тайлант үеийн эцэст өөрийн хөрөнгийн 30 хувиас хэтрэх, компанийн өр нь хоёр жил дараалан өөрийн хөрөнгөөс илүү болж, хасах утгатай болох нөхцөл байдал үүсэхээс урьдчилан сэргийлж, энэхүү нөхцөл байдал үүссэн тохиолдолд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мэдээлэл;
- 3.5.4. тайлант хугацаанд эргүүлэн худалдан авсан халаасны хувьцааны тоо, ширхэг, ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр хэрэгжүүлсэн, үнэт цаасаар урамшуулал олгосон талаарх мэдээлэл.
- 3.6. Үнэт цаас гаргагч нь Хорооноос баталсан компанийн засаглалын кодексийн дагуу холбогдох бодлого, журмыг батлан мөрдүүлж, хэрэгжилтийг тайлагнана. Үүнд:
- 3.6.1. Үнэт цаас гаргагч нь компанийн засаглалын кодекс заасан засаглалын зарчмуудын хэрэгжилтийг жилд нэгээс доошгүй удаа “засаглалын тайлан” хэлбэрээр тайлагнах бөгөөд тайланг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон компанийн цахим хуудсанд байршуулж, өөрчлөлт гарсан тухай бүр шинэчилнэ.
- 3.6.2. Үнэт цаас гаргагч нь компанийн засаглалын зарчмуудын хэрэгжилтийг тайлагнахдаа кодекс дурдсан зарчмуудыг хэрэгжүүлсэн эсэх, хэрэгжүүлээгүй бол яагаад хэрэгжүүлээгүй, түүнийг орлох бүтэц, биелүүлэх зорилт тавьсан бол хэрэгжүүлэх хугацааг кодексийн хавсралт 1 дүгээр маягтын дагуу тайлбарлах үүрэгтэй.
- 3.6.3. “Үнэт цаас гаргагч нь кодексийн хэрэгжилтийн тайландаа Биржээс баталсан компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг үнэлэх аргачлалын дагуу үнэлгээ хийж ирүүлнэ.
- 3.7. Биржийн үнэт цаасны бүртгэлийн I ангилалд бүртгэлтэй үнэт цаас гаргагч нь байгаль орчин, нийгэм, засаглал (цаашид “БОНЗ” гэх)-ын чиглэлээр тайлант хугацаанд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үйл ажиллагааны мэдээллийг хавсралт маягт 1-ийн дагуу гаргаж дараа жилийн 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ. Биржийн үнэт цаасны бүртгэлийн II болон III ангилалд бүртгэлтэй үнэт цаас гаргагч нь БОНЗ-ын тайланг дээрх тогтоосон хугацаанд сайн дурын үндсэн дээр ирүүлж болно. БОНЗ-ын тайланд дараах асуудлуудыг багтаан тайлагнана. Үүнд:
- 3.7.1. тогтвортой хөгжлийн менежмент системтэй холбоотой үзүүлэлтүүд гэдэгт тогтвортой хөгжлийн бодлого, бүтэц удирдлага, тайлагнал болон гишүүнчлэлтэй холбоотой асуудлууд;
- 3.7.2. байгаль орчны үзүүлэлтүүд гэдэгт эрчим хүч, хүлэмжийн хий, уур амьсгалын өөрчлөлт, ус, хог хаягдал, биологийн төрөл зүйл, нөөцийн зохистой хэрэглээ, сөрөг нөлөөлөл зэрэг асуудлууд;
- 3.7.3. нийгмийн үзүүлэлтүүд гэдэгт эрүүл аюулгүй ажиллах орчин, хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, ажилтны сурч хөгжих боломж, хүний эрх болон жендерийн эрх тэгш байдал, хүртээмж, ажлын байрны ёс зүй, эрх тэгш байдал, олон нийтийн

- харилцаа, нийгмийн хариуцлагатай үйл ажиллагаа, орон нутгийн хөгжилд чиглэсэн үйл ажиллагаа, туслалцаа дэмжлэг, худалдан авалтын бодлого зэрэг асуудлууд;
- 3.7.4. засаглалын үзүүлэлтүүд гэдэгт авлига, компанийн засаглал, комплайнс, оролцогч талуудын хамтын ажиллагаа зэрэг асуудлууд;
- 3.7.5. салбарын үзүүлэлтүүд гэдэгт банк, санхүү, хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэр, барилга, уул уурхай зэрэг салбарт үйл ажиллагааг явуулж буй үнэт цаас гаргагчдад тусгайлан хамаарах асуудлууд.
- 3.8. Хэрэв БОНЗ-ын үйл ажиллагааны тайлангийн маягтад заасан аливаа мэдээллийг үнэт цаас гаргагчаас цуглуулах, танилцуулах боломжгүй бол энэ талаарх шалтгаан болон мэдээллийг цаашид ил тод болгох талаар авч буй арга хэмжээний талаар “тайлбар” ирүүлнэ.
- 3.9. Энэ журмын 3.7-д заасан байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын тайланг хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар хянан баталгаажуулж болно.

Үнэт цаас гаргагчийн тухай бүр нийтэд мэдээлэх мэдээлэл

- 3.10. Үнэт цаас гаргагч нь тухай бүр ирүүлэх мэдээллийг Хорооны 225 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын дөрөвдүгээр хавсралтын дөрөв, Маягт 3-ын дагуу ирүүлнэ.
- 3.11. Биржийн үнэт цаасны бүртгэлийн I ангилалд бүртгэлтэй үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга эсхүл үнэт цаас хариуцсан мэргэжилтэн нь тухай бүр нийтэд мэдээлэх мэдээллийг Монгол болон Англи хэл дээр, II болон III ангилалд бүртгэлтэй үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга эсхүл үнэт цаас хариуцсан мэргэжилтэн нь Монгол болон сайн дурын үндсэн дээр мэдээллээ Англи хэл дээр гарган ажлын 1 өдөрт багтаан Хороо болон Биржид ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлэх үүрэгтэй.
- 3.12. Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны үнэ, ханш арилжааны хэмжээнд мэдэгдэхүйц нөлөөлж болох нөхцөл байдал үүсмэгц энэ тухай ажлын 1 өдөрт багтаан Биржид мэдэгдэж, олон нийтэд шуурхай мэдээлэх үүрэгтэй.
- 3.13. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 56 дугаар зүйл, Хорооны “Үнэт цаасны зах зээл дэх дотоод мэдээллийн жагсаалт, түүнийг мэдээлэх журам”-ын 2 дугаар бүлэг, энэ журмаар тогтоосон хугацаат ба тухай бүр ирүүлэх мэдээлэл, дор заасан үйл явдал, хэлцэл гүйлгээний баримт мэдээлэл нь ханшид нөлөөлөх мэдээлэлд багтах бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй болно. Үүнд:
- 3.13.1. үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлага, ТУЗ-өөс гаргасан үнэт цаасны үнэ ханшид болон компанийн үйл ажиллагаанд нөлөөлөх шийдвэрүүд;
- 3.13.2. нийт ажиллагсдын 15 болон түүнээс дээш хувьд өөрчлөлт орох буюу чөлөөлөгдөх, шилжих, шинээр ажилд орсон талаарх мэдээлэл;
- 3.13.3. үнэт цаас гаргагчийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний холбогдох этгээд, тэдгээрийн хувьцаа эзэмшилд гарсан өөрчлөлт;
- 3.13.4. үнэт цаас гаргагчийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болон тэдгээрийн бусад компанид эзэмшиж байгаа хувьцаанд гарсан өөрчлөлтийн талаарх мэдээлэл;

- 3.13.5. дотоод мэдээлэл эзэмшигч, түүний холбогдох этгээд, тэдгээрийн хувьцаа эзэмшилд гарсан өөрчлөлт;
- 3.13.6. үнэт цаас гаргагчийн эрхэлж буй үйл ажиллагааны салбарт эзлэх байр суурийн талаарх мэдээлэл, түүнд орсон өөрчлөлт;
- 3.13.7. үнэт цаас гаргагчийн охин, хараат компаниудын үйл ажиллагаатай холбоотой аливаа тусгай зөвшөөрөл эзэмших болсон эсхүл түүний хүчингүй болгосон, барьцаалсан, аливаа хэлбэрээр бусдад шилжүүлсэн тухай мэдээлэл;
- 3.13.8. үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлогын 20 ба түүнээс дээш хувьд нөлөөлөх үйл ажиллагаатай холбогдох аливаа тусгай зөвшөөрөл (лиценз) бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай байгуулсан гэрээ хэлцлийг цуцлах, дуусгавар болгосон талаарх мэдээлэл;
- 3.13.9. үнэт цаас гаргагч нь өөрийн үнэт цаасаа эргүүлэн худалдан авах, худалдан авсан хувьцаагаа бусдад шилжүүлэх, эргэлтэд гаргах тухай шийдвэрийг ирүүлнэ. шийдвэрт үнэт цаасыг худалдан авах (худалдах) зорилго, авах (эргэлтэд гаргах) хувьцааны тоо, үнэ, нийт хувьцаанд эзлэх хувь, төлбөр хийх хугацааны талаар тусгах;
- 3.13.10. үнэт цаас гаргагч нь их хэмжээний хэлцэл болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдсэн тохиолдолд тухайн мэдээллийг ирүүлэх;
- 3.13.11. дараа жилийн үйл ажиллагааны зорилго зорилтын талаарх мэдээлэл;
- 3.13.12. үнэт цаасны танилцуулгад тусгагдсан төслийн хэрэгжилт өөрчлөгдсөн бол энэ тухай мэдээлэл;
- 3.13.13. үнэт цаас гаргагчийн санхүү, үйл ажиллагааны тайлангийн аудитын дүгнэлтэд орсон өөрчлөлт;
- 3.13.14. санхүүгийн чадавхын зэрэглэл тогтоох үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдээр санхүүгийн чадавхын зэрэглэл тогтоолгосон болон түүнд орсон түүнд орсон өөрчлөлт;
- 3.13.15. үнэт цаас гаргагчийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч өөрийн хувь эзэмшилд ногдох хувьцааг ямар нэгэн байдлаар зээлийн үүргийн гүйцэтгэлийн барьцаа хангуулахаар барьцаанд тавьсан, баталгаа батлан даалт гаргасан бол энэ талаарх мэдээлэл;
- 3.13.16. хууль тогтоомж, Хорооны холбогдох журамд заасан бусад мэдээлэл.

Шинээр болон нэмж үнэт цаас гаргасан компаниудаас ирүүлэх мэдээлэл

- 3.14. Олон нийтээс татсан хөрөнгөөр санхүүжүүлэх төслийг бүрэн хэрэгжүүлэх хүртэл хугацаанд татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт, төслийн гүйцэтгэлийн тайланг улирал тутамд гаргаж, дараа сарын 15-ны дотор Биржид ирүүлнэ.
- 3.15. Өрийн хэрэгсэл гаргасан бол Хорооны “Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-ын 8-д заасан мэдээллийг Биржид ирүүлнэ.
- 3.16. Шинээр болон нэмж үнэт цаас гаргасан үнэт цаас гаргагчийн төслийн явцтай газар дээр очиж хяналт, шалгалтыг Гүйцэтгэх захирлын удирдамжийн дагуу хийж болно.

Дөрөв.Хяналт, хариуцлага

- 4.1. Үнэт цаас гаргагч нь энэхүү журам болон Бүртгэлийн гэрээг зөрчсөн эсхүл хэрэгжүүлээгүй тохиолдолд дараах хариуцлагыг хүлээлгэнэ. Үүнд:
 - 4.1.1. анхааруулах;
 - 4.1.2. бүртгэлийн гэрээний дагуу хариуцлага ногдуулах;
 - 4.1.3. үнэт цаасны ангилал бууруулж бүртгэх;
 - 4.1.4. Бирж дээр нэмж үнэт цаас гаргах эрхийг хязгаарлах;
 - 4.1.5. үнэт цаасны арилжаа зогсоох саналыг хороонд хүргүүлэх;
 - 4.1.6. үнэт цаасыг бүртгэлээс хасах.
- 4.2. Журмын 4.1-д заасан зөрчлийн дагуу анхааруулга авсан үнэт цаас гаргагч нь зөрчлийг арилгах төлөвлөгөө, зөрчлийг арилгасан тухай тайланг заасан хугацаанд ирүүлэх үүрэгтэй.
- 4.3. Анхааруулах арга хэмжээг цаасаар болон цахим хэлбэрээр хүргүүлж болно.
- 4.4. Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн тайлан, тайлбар, хэрэгжүүлсэн арга хэмжээг хангалтгүй гэж үзсэн тохиолдолд Бирж нь нэмэлт тайлбар, тодруулга ирүүлэхийг шаардаж болно.
- 4.5. Үнэт цаас гаргагчид ногдуулсан хариуцлагын арга хэмжээ, түүний шалтгаан болон хэрэгжилтийн талаар Бирж өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.
- 4.6. Үнэт цаас гаргагчийн гаргасан зөрчлийг харгалзан дээрх хариуцлагын хэлбэрүүдийг заавал шат дараалан оногдуулахгүй байж болно.
- 4.7. Биржээс шаардлагатай гэж үзсэн тохиолдолд үнэт цаас гаргагчийн ажлын байранд газар дээрх шалгалтыг хийж болно.
- 4.8. Энэ журамд заасан мэдээллийг холбогдох маягтаар тогтоосон хугацаанд ирүүлээгүй, худал хуурмаг, төөрөгдүүлсэн шинжтэйгээр ирүүлсэн гэж үзсэн тохиолдолд Бирж нь Хороонд тухай бүр мэдээлнэ.

Тав.Маргаан шийдвэрлэх

- 5.1. Үнэт цаас гаргагч нь Биржээс гаргасан аливаа мэдэгдэл, шийдвэрийг эс зөвшөөрвөл уг мэдэгдэл, шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор холбогдох эрх бүхий этгээдэд гомдол гаргаж болно.

---o0o---



БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Энэхүү тайлан нь "Монголын хөрөнгийн бирж" ХХК-д бүртгэлтэй компаниудын байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын чиглэлээр тайлант хугацаанд авч хэрэгжүүлсэн стратеги, арга хэмжээ, нөхцөл байдлыг хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчид, олон нийтэд ил тод нээлттэй тайлагнах зорилготой. Хэсэг 1, 2, 3 нь нийт үнэт цаас гаргагч компаниудад хамааралтай бөгөөд Хэсэг 4 нь зөвхөн тухайн салбарт үйл ажиллагаа явуулж буй үнэт цаас гаргагчдад хамаарна. Хэрэв тайлангийн маягтад заасан аливаа мэдээллийг цуглуулах, тайлагнах боломжгүй бол тайлагнах боломжтой талаарх тайлбар, цаашид мэдээллийг тайлагнах чиглэлд авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар 'тайлбар' хэсэгт бичнэ үү.

Огноо (он, сар, өдөр):	
Үнэт цаас гаргагчийн нэр:	
Үнэт цаасны нэр, код (МХБ символ):	
Салбарын ангилал:	
Тайланд орсон компаниуд (энэхүү тайланд орсон толгой болон охин компаниудын мэдээлэл):	
Тайлангийн хамрах хугацаа:	
Хариуцсан албан тушаалтны овог нэр, албан тушаал, холбоо барих и-мэйл хаяг, утас:	
Тайланг баталгаажуулсан гүйцэтгэх удирдлагын мэдээлэл (нэр, албан тушаал):	
Гүйцэтгэх удирдлага эсвэл ТУЗ-ийн даргын гарын үсэг:	

	Бүлэг	Шалгуур үзүүлэлт		Үзүүлэлт (өмнөх он)	Үзүүлэлт (тайлант он)	Хэмжих нэгж	Нэмэлт мэдээлэл	Тайлбар	Холбоос
		Тогтвортой хөгжлийн удирдлагын системтэй холбоотой шалгуур үзүүлэлтүүд							
MS1.1	Тогтвортой хөгжлийн удирдлагын систем	Удирдлагын амлалт	Удирдлагаас баталсан тогтвортой хөгжлийн амлалт/мэдэгдэл байдаг эсэх		1.Тийм 2.Үгүй		Линк болон огноог оруулна уу.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 102
MS2.1		Тогтвортой хөгжлийн бодлого, зохицуулалт	Тогтвортой хөгжлийн бодлого, зорилтуудыг тодорхойлж баталсан эсэх		1.Тийм 2.Үгүй		Линк оруулна уу.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 103, ISO 14001
MS2.2		Бүтэц удирдлага	Танай компани тогтвортой хөгжлийн асуудал хариуцсан хороо байдаг эсэх		1.Тийм 2.Үгүй		Хариуцсан хороо/гишүүдийг бичнэ үү.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 103, ISO 14001
MS3.1			ТУЗ-ийн түвшинд тогтвортой хөгжил / БОНЗ-ын асуудал хариуцсан гишүүн (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх		1.Тийм 2.Үгүй		Хариуцсан албан тушаалыг бичнэ үү.		GRI 102
MS3.2			Гүйцэтгэх удирдлагын түвшинд тогтвортой хөгжил/ БОНЗ-ын асуудал хариуцсан албан тушаалтан (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх		1.Тийм 2.Үгүй		Хариуцсан албан тушаалыг бичнэ үү.		GRI 102
MS3.3			Үйл ажиллагааны түвшинд тогтвортой хөгжил/ БОНЗ-ын асуудал хариуцсан албан тушаалтан (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх		1.Тийм 2.Үгүй		Бүртгэл хариуцсан ахлах мэргэжилтэн	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 102
MS3.4			Танай компани ТУЗ-ийн хурлын хөтөлбөрт тогтвортой хөгжлийн асуудлыг албан ёсоор тусгадаг уу?		1.Тийм 2.Үгүй			мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 102

MS3.5		Тогтвортой байдлын нөлөөллийн үнэлгээ	Танай компани эдийн засаг, байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллөөс хэрхэн зайлсхийх, бууруулах, арилгах, эерэг үр нөлөөг сайжруулах талаар тайлбарласан нөлөөллийн үнэлгээ эсвэл матриц байдаг эсэх		1.Тийм 2.Үгүй		Линк оруулна уу.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	SASB
MS4.1		Чадавх бүрдүүлэлт	Нэг ажилтанд ногдох тогтвортой хөгжлийн тухай сургалтын жилийн дундаж цаг, хүйсээр			цаг	Захиргаа, санхүүгийн газрын захирал, эмэгтэй-1	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 102
MS4.2		Хяналт	Тогтвортой байдлын асуудал нь аудитын хорооны үйл ажиллагаа, дотоод хяналтын чиг үүрэгт хамаардаг уу?		1.Тийм 2.Үгүй		Дотоод аудит/аудитын хорооны үүрэг, хариуцлагыг бичнэ үү.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 102, SDG 12
MS4.3		Тогтвортой байдлын тайлагнал	Танай компани тогтвортой байдал/ хөгжлийн тайлан (жилийн тайланд нэгтгэдэг эсвэл тусдаа тайлан)-гаа жил нэгээс доошгүй удаа тайлагнадаг уу?		1.Тийм 2.Үгүй		Линк оруулна уу.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 102, SDG 12
MS5.1			Танай компани олон улсын уур амьсгалын эрсдэлийн стандартын дагуу тайлагнадаг уу?		1.Тийм 2.Үгүй		Линк оруулна уу.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 102, SDG 12
MS5.2		Гишүүнчлэл, хамтын ажиллагаа	Танай компани тогтвортой хөгжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын болон дотоодын холбоо, нэгдэлтэй нэгдэж хамтран ажилладаг уу?		1.Тийм 2.Үгүй		Холбоо, нэгдлийн нэрийг бичнэ үү.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 102, SDG 17
MS6.1	Байгаль орчны шалгуур үзүүлэлтүүд								
E1.1	Эрчим хүч	Нийт эрчим хүчний хэрэглээ	Эрчим хүчний нийт зарцуулалтын хэмжээ болон зардал			Mega Втц '000	Эрчим хүчний гол эх үүсвэрийн төрлүүдээ бичнэ үү.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 302, SDG 12
E1.2		Цахилгаан	Цахилгааны нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр)			Mega Втц '000	Эрчим хүчний хэмнэлт бий болгосон төсөл, санаачилгуудаа товч бичнэ үү.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 302, SDG 12
E1.3		Дулаан	Дулааны нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр)			BTU & % Гкал	Дулааны хэмнэлт бий болгосон төсөл, санаачилгуудаа товч бичнэ үү.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 302, SDG 12
E1.4		Түлш	Түлшний нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр)			Литр/кг & %, ГЖоуль, Төгрөг	Түлшний хэмнэлт бий болгосон төсөл, санаачилгуудаа товч бичнэ үү.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 302, SDG 12
E1.5		Хүрэн эрчим хүч	СЭХ-ээс бусад эх үүсвэрээс авсан эрчим хүчний хэрэглээний хувь			%	Эрчим хүчний үүсвэрийн төрөл (нүүрс, газрын тос, хий гэх мэт)-ийг бичнэ үү.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	SFRD
E1.6		Сэргээгдэх эрчим хүч	СЭХ үүсвэрээс гаргаж авсан эрчим хүчний хэрэглээний хувь			%	СЭХ-ний үүсвэрийн төрөл (нар, салхи гэх мэт)-ийг бичнэ үү.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 302, SDG 7
E2.1	Хүлэмжийн хийн ялгарал	3.1 Хүлэмжийн хийн ялгаруулалт	Компанийн шууд ба шууд бус үйл ажиллагаанаас ялгарсан нийт хүлэмжийн хийн дүн			CO2/тонн	Хүлэмжийн хийг тооцоолохдоо ашигласан аргачлалаа товч тайлбарлана уу.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 305, SDG 13, WRI/WBCSD GHG protocol.
E2.2		3.2 Бууруулсан хүлэмжийн хий	Байгууллагын шууд ба шууд бус үйл ажиллагаанаас ялгарсан хүлэмжийн хийн нийт дүн (жилээр)			CO2/тонн	Хүлэмжийн хийг тооцоолохдоо ашигласан аргачлалаа товч тайлбарлана уу.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 305, SDG 13, WRI/WBCSD GHG protocol.

E2.3		3.3 Дүйцүүлэх арга хэмжээ /Карбон офсет/	Нийт карбон офсет буюу дүйцүүлэх арга хэмжээний (мод тарих хөтөлбөр, эсвэл хүлэмжийн хийг бууруулах гаднын төслийг дэмжих гэх мэт)бууралт			CO2/тонн	Авч хэрэгжүүлдэг арга хэмжээг бичнэ үү.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 305, SDG 13, WRI/WBCSD GHG protocol.
E3.1	Уур амьсгалын өөрчлөлт	Уур амьсгалын бодлого, журам	Танай компани уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг тусдаа эсвэл бусад журамд тусгасан бодлоготой юу?		1.Тийм 2.Үгүй		Линк оруулна уу.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 201, TCFD, SDG 13
E3.2		Уур амьсгалын эрсдэл ба боломжийн үнэлгээ	Танай компани уур амьсгалын эрсдэл, боломжийн талаарх үнэлгээ хийсэн үү?(сценарийн шинжилгээ, стресс тест гэх мэт)		1.Тийм 2.Үгүй		Линк оруулна уу.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 201, TCFD, SDG 13
E3.3		Эдийн засгийн хохирол	Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшиг, үйл явдлын улмаас учирсан эдийн засгийн нийт хохирлын хэмжээ			Төгрөг	Үнэт цаас гаргагчид нөлөөлсөн, нөлөөлж болзошгүй уур амьсгалын эрсдэл, үйл явдлууд, тэдгээрийг зохицуулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг бичнэ үү.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 201, TCFD, SDG 13
E3.4		Уур амьсгалын хөрөнгө оруулалт	Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг дэд бүтэц, дасан зохицол, бүтээгдэхүүн хөгжилд оруулсан нийт хөрөнгө оруулалтын дүн			Төгрөг	Хөрөнгө оруулалтын төрлийг бичнэ үү.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 201, TCFD, SDG 13
E3.5		Уур амьсгалын өөрчлөлтөөс урьдчилан сэргийлэх эсвэл дасан зохицох	Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор танай компанийн ашигт ажиллагаа эсвэл бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарт нөлөөлөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, (хэрэв урьдчилан сэргийлэх боломжгүй бол) дасан зохицох чиглэлд хэрэгжүүлэх арга хэмжээ/алхмуудыг тодорхойлсон уу?		1.Тийм 2.Үгүй		Авч хэрэгжүүлдэг арга хэмжээний талаар товч бичнэ үү.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI, SASB, World Economic Forum
E4.1	Ус	Усны хэрэглээ	Ашигласан усны нийт хэмжээ			м3/Л		мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 303, SDG 6
E4.2		Хэмнэсэн ус	Хэмнэлт, үр ашгийг дээшлүүлснээр нийт хэмнэсэн/дахин боловсруулсан усны хэмжээ			м3/Л	Хэмнэлт, үр ашгийг дээшлүүлсэн арга хэмжээгээ бичнэ үү.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 303, SDG 6
E4.3		Дахин боловсруулсан ус	Дахин ашигласан болон боловсруулсан усны эзлэх хувь			%	Дахин ашигласан, боловсруулсан арга хэмжээгээ бичнэ үү.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 303, SDG 6
E4.4		Хаягдал бохир ус цэвэрлэх	Цэвэрлэсэн нийт хаягдал бохир усны хэмжээ			м3/Л	Бохир усаа цэвэрлэсэн арга, нийлүүлсэн газрын талаар бичнэ үү.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 303, SDG 6
E5.1	Хатуу хог хаягдал	Хог хаягдал	Нийт ялгаруулсан хог хаягдлын хэмжээ			тонн	Хог хаягдлын төрөл, зайлуулах арга хэмжээний талаар бичнэ үү.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 306, SDG 12
E5.2		Дахин боловсруулсан хатуу хог хаягдал	Хог хаягдлыг дахин боловсруулсан хувь			%	Дахин боловсруулах аргаа бичнэ үү.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 306, SDG 12
E5.3		Хортой хог хаягдал	Хортой хог хаягдлын нийт хэмжээ (Үүнд цахилгаан хэрэгслийн хог орно)			тонн	Хог хаягдлын төрөл, устгалын аргаа бичнэ үү.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 306, SDG 12
E6.1	Биологийн олон янз байдал	Ногоон байгууламж, төлөвлөлт	Байгаль орчны хувьд тогтвортой ашиглаж буй нийтийн эзэмшлийн талбай буюу барьсан ногоон байгууламжийн талбайн нийт талбайд эзлэх хувь			%	Ногоон байгууламжийн төрөл байршлыг бичнэ үү.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 304, SDG 15
E6.2		Зэрлэг ургамал, амьтдыг хамгаалах	Хамгаалсан төрөл зүйлийн тоо			Төрөл зүйлийн тоо	Зэрлэг ургамал, амьтдыг хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажлуудын талаар бичнэ үү.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 304, SDG 15
E6.3		Биологийн олон янз байдалд сөргөөр нөлөөлж буй үйл ажиллагаа	Тусгай хамгаалалттай газар нутаг, биологийн олон янз байдал, соёлын үнэ цэнэ өндөртэй газар нутгийг эзэмшиж, түрээсэлсэн, удирдаж байгаа эсвэл зэргэлдээх үйл ажиллагааны талбайн нийт талбайд эзлэх хувь			%	Үнэлгээний талаар товч тайлбарлана уу.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	SFRD, IFC Performance Standard 6
		Нийгмийн шалгуур үзүүлэлтүүд							

S1.1	Хүний нөөц	Хүний нөөцийн тогтвортой байдал	Үндсэн ажилтнуудын ажлын байрны сэлгээний хувь (тухайн онд ажлаасаа гарсан ажилтнуудын тоог ажилласан ажилтнуудын дундаж тоонд хуваах)		%		мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 401, SDG 8	
S1.2		Шинээр бий болгосон ажлын байр	Өмнөх оны мөн үеэс нэмэгдсэн бүтэн цагийн ажлын байрны тоо		Тоо		мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 401, SDG 8	
S1.3		Сургалт	Нэг ажилтанд ногдох жилийн дундаж сургалтын цаг			цаг		мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 401, SDG 8
S2.1	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (ХАБЭА)	ХАБЭА-н бодлого	ХАБЭА-н бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?		1.Тийм 2.Үгүй	Линк оруулна уу.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 103, SDG 10	
S2.2		Осол аваар	Үйл ажиллагааны явцад гарсан осол аваарын хувь		%	Осол гэмтлийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажлуудаа бичнэ үү.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 403, SDG 3	
S2.3		ХАБЭА-н сургалт	Жилд нэг ажилтанд ногдох дундаж ХАБЭА сургалтын цаг			цаг		мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 403, SDG 3
S2.4		Эрүүл мэндийн хөтөлбөр	Эрүүл мэндийн үзлэг зэрэг сайн дурын эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдсан ажилчдын тоо, жилээр			хүн	Эрүүл мэндийн үйлчилгээний төрлүүдээ бичнэ үү.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 403, SDG 3
S3.1	Эрх тэгш байдал	Жендерийн бодлого, журам	Жендерийн бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?		1.Тийм 2.Үгүй	Линк оруулна уу.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 405, SDG 5	
S3.2		Ажлын байрны бэлгийн дарамтын эсрэг бодлого, журам	Бэлгийн дарамтын эсрэг бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?		1.Тийм 2.Үгүй	Линк оруулна уу.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 103, SDG 5	
S3.3		Ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлого, журам	Ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?		1.Тийм 2.Үгүй	Линк оруулна уу.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 103, SDG 10	
S3.4		Ажилтнуудын хүйсийн харьцаа	Нийт үндсэн ажилтнуудын тоонд эрэгтэй, эмэгтэй ажилтны эзлэх хувь			%		мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 405, SDG 5
S3.5		Удирдах зөвлөлийн хүйсийн харьцаа	Удирдах зөвлөлийн гишүүдийн эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа			%		мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 405, SDG 5
S3.6		Гүйцэтгэх удирдлагын хүйсийн харьцаа	Гүйцэтгэх удирдлагын түвшний ажилтнуудын эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа			%		мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 405, SDG 5
S3.7		Дунд болон анхан шатны нэгжийн ажилтнуудын хүйсийн харьцаа	Дунд болон анхан шатны нэгжийн ажилтнуудын эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа			%		мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 405, SDG 5
S3.8		Жендерт суурилсан цалингийн зөрүү	Эрэгтэй ба эмэгтэй ажилтнуудын дундаж цалингийн харьцаа			харьцаа		мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 405, SDG 5, SFRD
S4.1	Хүртээмжтэй байдал	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бодлого, журам	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?		1.Тийм 2.Үгүй	Линк оруулна уу.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	SDG 10	
S4.2		Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнууд	Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудын нийт ажилтны тоонд эзлэх хувь			%		мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	SDG 10
S4.3		Оффисын хүртээмж	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдлаар шийдсэн оффис, байгууламжтай юу		1.Тийм 2.Үгүй		Авч хэрэгжүүлсэн арга хэмжээг бичнэ үү.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	SDG 10
S4.4		Торгууль	Байгаль орчны зөвшөөрөл, стандарт, дүрэм журмыг дагаж мөрдөөгүйгээс гарсан зөрчлийн тоо			Төгрөг	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээг бичнэ үү.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	SDG 10
S5.1	Нийгмийн хариуцлага ба ил тод байдал	Оролцогч талуудын оролцооны засаглал	Оролцогч талуудтай хамтарч ажиллах талаар тусгайлсан бодлого байгаа юу?		1.Тийм 2.Үгүй	Линк оруулна уу.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	IFC	
S5.2		Нийгмийн нөлөөллийн үнэлгээ, газар чөлөөлөлтийн бодлого журам	Танай компани нийгэмд нөлөөлөх байдлын бодлого, журамтай юу? (Үнд газар чөлөөлөлт багтана)		1.Тийм 2.Үгүй		мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	IFC Performance Standards	

S5.3		Санал гомдлыг шийдвэрлэх бодлого/журам	Гомдол маргааныг шийдвэрлэх бодлого, механизм бий юу?		1.Тийм 2.Үгүй	Линк оруулна уу.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 102, SDG 16	
S5.4		Олон нийтэд ил тод мэдээлэх	Танай компанийн үйл ажиллагаа нөлөөлж буй иргэдэд мэдээлэл өгөх, санал хүсэлт авч, гомдол шийдвэрлэх тогтолцоо бий юу?		1.Тийм 2.Үгүй	Олон нийтэд мэдээлэл өгөх, санал гомдлыг шийдвэрлэх талаар хэрэгжүүлж буй арга хэмжээг бичнэ үү.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	IFC Performance Standards	
S5.5		Ажилчид/олон нийтийн санал гомдол	Ажилчид болон олон нийтээс ирсэн санал гомдлыг шийдвэрлэсэн хувь		%		мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 413, SDG 8	
S5.6		Нийгмийн хариуцлагын үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгө оруулалт	Нийгмийн хариуцлагын арга хэмжээ, хөтөлбөрт зарцуулсан хөрөнгө оруулалтын нийт орлогод эзлэх хувь		%	Нийгмийн хариуцлагын чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тухай бичнэ үү.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 413, SDG 8	
S6.1	Тогтвортой өртгийн сүлжээний менежмент	Худалдан авалтын бодлого, журам	Танай компанид дотоодын худалдан авалт болон тогтвортой буюу байгаль орчин, нийгмийн эрсдэл боломжийг хангасан худалдан авалтын бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?		1.Тийм 2.Үгүй	Линк, шинэчилсэн бодлого журмын огноо оруулна уу.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 204, SDG 8	
S6.2		Дотоодын худалдан авалт	Дотоодын ханган нийлүүлэгчдээс авсан худалдан авалтын хувь		%		мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 204, SDG 8	
S6.3		Тогтвортой, ногоон худалдан авалт	Нийт ханган нийлүүлэгчдийн тоонд тогтвортой буюу байгаль орчин, нийгмийн шалгуураар сонгогдсон ханган нийлүүлэгчдийн хувь			%	Тогтвортой аргаар нийлүүлсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлийг бичнэ үү.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 204, SDG 8
Засаглалын шалгуур үзүүлэлтүүд									
G1.1	Авлигал болон ёс зүй	Авлигын эсрэг бодлого журам	Авлигын эсрэг эсвэл Ёс зүйн бодлого, журам бий юу?		1.Тийм 2.Үгүй	Линк оруулна уу.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 205, SDG 16	
G2.1	Компанийн засаглал	Удирдах зөвлөлийн хараат бус байдал	Удирдах зөвлөлд хараат бус гишүүдийн суудлын хувь		%		мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 102, OECD Principles of Corporate Governance, SDG 16	
G2.2		Цөөнх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх	Цөөнх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах дүрэм, журам бий юу?		1.Тийм 2.Үгүй	Линк оруулна уу.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 102, OECD Principles of Corporate Governance, SDG 16	
G2.3		Компанийн засаглалын бодлого, журам	Компанийн засаглалын бодлого, журам бий юу?			1.Тийм 2.Үгүй	Линк оруулна уу.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 102, OECD Principles of Corporate Governance, SDG 16
G3.1	Комплаенс	Комплаенсын бодлого	Комплаенсын бодлого, журам бий юу?		1.Тийм 2.Үгүй	Линк оруулна уу.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 102, OECD Principles of Corporate Governance, SDG 16	
G3.2		Комплаенсын хөтөлбөр	Комплаенсын хөтөлбөр, журам (ажилчдын сургалт, аудит, хяналтын систем, зөрчлийн талаар мэдээлэх, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх удирдамж, хориг гэх мэт) бий юу?			1.Тийм 2.Үгүй	Линк оруулна уу.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 102, OECD Principles of Corporate Governance, SDG 16
Нэмэлт салбарын шалгуур үзүүлэлтүүд (Танай компанид хамаарах салбарын асуултуудыг бөглөнө үү)									
FS1	Санхүүгийн үйлчилгээ	Санхүүгийн хүртээмж	Санхүүгийн мэдлэг дээшлүүлэх болон санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах санаачилга, арга хэмжээнд оролцсон хүмүүсийн тоо, жилээр			хүн	Санхүүгийн мэдлэг дээшлүүлэх, санхүүгийн хэрэглэгчийг хамгаалах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг бичнэ үү.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	SDG 1
FS2		БОНЗ-ын эрсдэлийн менежмент	БОНЗ-ын эрсдэлийн шалгуур болон хориотой үйл ажиллагааны жагсаалтаар үнэлсэн гүйлгээний хувь			%	БОНЗ-ын хянан баталгаажуулалтын процессыг бичнэ үү.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	Mongolian Sustainable Finance Principles

F53		Тогтвортой санхүүжилт	Нийт зээлийн багцад эзлэх ногоон/ТХЗ таксономийн ангилалд нийцсэн ногоон/тогтвортой зээлийн эзлэх хувь		%	Ногоон/тогтвортой санхүүгийн бүтээгдэхүүнийг бичнэ үү.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	SDG 13, Mongolia Green Taxonomy
A1	Хөдөө аж ахуй & хүнсний үйлдвэрлэл	Устгалын бодис	Устгалын бодис ашиглах бодлого журам бий юу?		1.Тийм 2.Үгүй	Линк оруулна уу.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 403, SDG 12
A2		Тогтвортой газар, бэлчээр	MNS 6891:2020, Хариуцлагатай нүүдэлчин стандарт эсвэл түүнтэй ижил төстэй тогтвортой бэлчээрийн стандартыг хэрэгжүүлж чадсан бэлчээрийн талбайн хувь		%		мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	SDG 12
A3		Буцаан татан авсан бараа бүтээгдэхүүн	Хүнсний чанар, аюулгүй байдлыг хангаагүй буцаагдсан эсвэл худалдах боломжгүй болсон бүтээгдэхүүний хувь		%		мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 416, SDG 12
T1	Текстиль	Тогтвортой мал аж ахуй	MNS 6891:2020, Хариуцлагатай нүүдэлчин стандарт эсвэл түүнтэй ижил төстэй тогтвортой бэлчээрийн стандартыг нэвтрүүлсэн малын тоо, бэлчээрийн эзлэх хувь		но. & %		мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 403, SDG 12
T2		Тогтвортой аргаар үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн	Текстилийн тогтвортой үйлдвэрлэлийн стандартын (MNS 6926:2021) дагуу үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тоо, эзлэх хувь		но. & %		мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 416, SDG 12
T3		Химийн бодисын менежмент	Химийн бодис болон хортой материалыг зохистой хадгалах бодлого, журам		1.Тийм 2.Үгүй		мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 403, SDG 12
MA1	Боловсруулах	Химийн бодисын менежмент	Химийн бодис болон хортой материалыг зохистой хадгалах бодлого, журам		1.Тийм 2.Үгүй	Линк оруулна уу.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 403, SDG 12
MA2		Дахин боловсруулсан материал	Дахин боловсруулсан материал, орц ашиглалтын хувь		%		мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	SDG 12
MA3		Ногоон шошго, гэрчилгээжүүлсэн байдал	Эко буюу ногоон шошго, гэрчилгээтэй бүтээгдэхүүний эзлэх хувь		%		мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 417, SDG 12
MI1	Уул уурхай	Нөхөн сэргээлт	Нийт ашиглалтын зориулалттай газартай харьцуулахад нөхөн сэргээлт хийсэн газрын талбайн хувь		%		мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	SDG 15
MI2		Торгууль	Байгаль орчны зөвшөөрөл, стандарт, дүрэм журмыг дагаж мөрдөөгүйгээс гарсан зөрчлийн тоо		Зөрчлийн тоо		мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 307, SDG 15
MI3		Нүүлгэн шилжүүлэлт	Эдийн засгийн шилжилт хөдөлгөөн, нүүлгэлтэд хамрагдсан иргэдийн тоо		Хүн		мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 203, SDG 1
CO1	Барилга	Ногоон барилгын шошго/гэрчилгээ	Ногоон барилгын шошго/гэрчилгээ авсан барилгын төслүүдийн хувь		%	Гэрчилгээ авсан төслүүдээ бичнэ үү	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 417, SDG 12
CO2		Хүртээмжтэй байдал	Монгол Улсын хэрэгжиж буй хүртээмжтэй байдлын тухай хууль тогтоомжид нийцсэн барилгын төслүүдийн хувь (үүнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүртээмжийг мөн харгалзана)		%	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээг бичнэ үү.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	SDG 10
CO3		Ногоон байгууламж, талбай	Монгол Улсын ногоон байгууламж, нийтийн талбайн хууль тогтоомжид нийцсэн барилгын төслүүдийн хувь		%	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээг бичнэ үү.	мэдээлэл байхгүй бол тайлбар бичнэ үү.	GRI 304, SDG 15